

**ЗАСГИЙН ГАЗРААС БАТАЛСАН**  
**“ЖИЖИГ, ДУНД ҮЙЛДВЭРИЙГ ДЭМЖИХ” ХӨТӨЛБӨРИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ЯВЦАД**  
**ХИЙСЭН ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН**  
 2009 оны жилийн эцсийн байдлаар

2010.03.10

Д.д	Хөтөлбөрийн агуулга		Гүйцэтгэл
1	ЗГ-ын тогтоолын дугаар, огноо		Хөтөлбөрийг Засгийн газрын 2005 оны 64 дүгээр тогтоолоор баталсан. Засгийн газрын 2009 оны 280 тогтоолоор хөтөлбөрт өөрчлөлт оруулсан.
2	Хөтөлбөр хэрэгжүүлж хугацаа		2005 - 2010 он
3	Хөтөлбөрийн зорилго		<b>Хөтөлбөрийн зорилго</b> нь жижиг, дунд үйлдвэрийг эрчимтэй хөгжүүлж өрсөлдөх чадварыг дээшлүүлэх, албан бус бизнес эрхлэгчдийг албан ёсны жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэх тааламжтай нөхцлийг бүрдүүлэх, ажлын байр шинээр бий болгох, нэмэгдүүлэхэд оршино.
4	Хөтөлбөрийн зорилтууд /үе шатаар/	Зорилтууд	Хөтөлбөрийн зорилгыг хангахын тулд <b>дараахь зорилтуудыг</b> хэрэгжүүлнэ. Үүнд: - жижиг, дунд үйлдвэрлэлийн хөгжлийг дэмжих эрх зүйн таатай орчинг бүрдүүлэх; - төрийн захиргааны байгууллагаас жижиг, дунд үйлдвэр эрхлэгчдэд үзүүлж байгаа үйлчилгээг шуурхай, чирэгдэлгүй болгох; - жижиг, дунд үйлдвэрийг татвар, санхүүгийн бодлогоор дэмжих; - жижиг, дунд үйлдвэрлэлийн хэрэгцээ, шаардлагад нийцсэн сургалт явуулах, мэдээллээр хангах, зөвлөлгөө өгөх, дэмжлэг үзүүлэх тогтолцоог бий болгох.
		1 дүгээр үе шат 2005–2006 он	а/ Жижиг, дунд үйлдвэр хөгжих эрх зүйн орчинг бүрдүүлэх, журам, стандарт, техникийн нөхцөл зэрэг баримт бичгийг боловсруулах, шинэчлэн батлуулах; б/ “Жижиг, дунд үйлдвэрийг дэмжих сан”-г шинэчлэн “Жижиг, дунд үйлдвэрийг дэмжих Хөрөнгө оруулалт, хөгжлийн сан” болгон зохион байгуулж ажиллуулах; в/ Төрийн үйлчилгээний талаарх санал хүсэлт, гомдлыг хүлээн авах “Шуурхай үйлчилгээний цэг”-ийг байгуулах; г/ Мэргэжлийн холбоодын нэгдсэн зөвлөл байгуулж шийдвэр боловсруулах явцад санал, зөвлөмж авч байх; д/ Үл хөдлөх хөрөнгийн бүртгэлийн цэгийг хэрэгцээг харгалзан нэмж байгуулах; е/ Лиценз, зөвшөөрөл олгох үйл ажиллагааг хялбарчлах, цахим сүлжээгээр олгох; ж/ Хөрөнгийн асуудал шийдэгдэх хэмжээгээр бизнес инкубатор, технологи дамжуулах төв байгуулах
		2 дугаар үе шат: 2007–2008 он	а) Нэгдүгээр үе шатанд хэрэгжүүлсэн арга хэмжээг дуусгах; б/ Технологи дамжуулах төвийг хот, суурин газар болон бүсийн төвүүдэд байгуулах; в) Бизнес инкубаторыг бүсийн төв, хотод байгуулах; г) Мэргэжлийн сургалтын төвүүдийг бүсийн төвүүд, хот суурин газруудад байгуулах.
		3 дугаар үе шат: 2009–2010 он	а) 1, 2 дугаар үе шатанд хэрэгжүүлэх арга хэмжээг дуусгах; б) мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төвийг бүсчлэн байгуулах; в) тоног төхөөрөмжийг жижиг, дунд үйлдвэр эрхлэгчдэд санхүүгийн түрээс (лизинг)-ээр олгох үйлчилгээ хариуцсан нэгж байгуулж ажиллуулах;

			<p>г) жижиг, дунд үйлдвэр эрхлэгчдийн хөдөлмөр хамгаалал, сургалт, мэдээллийн үйлчилгээг гэрээний үндсэн дээр мэргэжлийн холбоодоор гүйцэтгүүлэх;</p> <p>д) жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сан, хөрөнгө оруулалт, хөгжлийн сангийн хөрөнгийн эх үүсвэрийг нэмэгдүүлэх арга хэмжээ авах;</p> <p>е) жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх чиглэлээр гадаадын хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх ажлыг зохион байгуулах;</p> <p>з) жижиг, дунд үйлдвэрийг дэмжих талаар Засгийн газраас явуулж байгаа бодлого, үйл ажиллагааг сурталчлах;</p> <p>ж) албан бус хөдөлмөр эрхлэгчдийн дунд жижиг, дунд үйлдвэр эрхлэх чиглэлээр төрөлжсөн сургалт зохион байгуулах.</p>							
5	Зарцуулсан хөрөнгө	Төсөв /шаардагдах нийт зардал/	Нийт 19410.0 сая төг. (Үүнээс 15 000.0 сая төгрөг нь Мянганы сорилтын сан, Японы Засгийн газрын 2 үе шаттай зээл, бусад)							
		Гүйцэтгэл /өссөн дүнгээр/	2006-2008 оны нийт эх үүсвэрээс 451 төсөлд 4.6 тэрбум төгрөгийн, 2009 онд 1528 төсөлд 25.8 тэрбум төгрөгийн хөнгөлөлттэй зээл олгожээ.							
		тухайн жилд зарцуулсан	30.8 тэрбум төгрөг							
6	Хөтөлбөрийн хэрэгжилтийн үнэлгээ	Биелэлтийн хувь	Нийт	100	90	80	70	50	30	Дундаж
		I шатны хэрэгжилтийн явц	4	1	2		1			90%
		II шатны хэрэгжилтийн явц	4		3	1				90%
		III шатны хэрэгжилтийн явц	4			1(3)	1(1)	1(2)	1(4)	60%
7	Шалгуур үзүүлэлтийн гүйцэтгэл	Төлөвлөсөн	Гүйцэтгэл							
		Жижиг, дунд үйлдвэр хөгжих эрх зүйн орчин бүрдэж, өрсөлдөх чадвартай жижиг, дунд үйлдвэр хөгжиж, тэд зах зээлд өөрийн байр суурийг эзэлж, дотоодын нийт бүтээгдэхүүний өсөлт болон ажилгүйдэл, ядуурлыг бууруулсан байх	<p>ЖДҮ эрхлэгчдийн тоо өмнөх оныхоос 2006 онд 36.6, 2007 онд 4.2, 2008 онд 13.7, 2009 оны урьдчилан гүйцэтгэлээр 1.5 хувиар өсчээ.</p> <p>ЖДҮ-ийн үйлдвэрлэсэн бүтээгдэхүүний жилийн өсөлт өмнөх онтой нь харьцуулахад 2006 онд 60, 2007 онд 10.7 хувь өсч, аж үйлдвэрийн нийт үйлдвэрлэлтэд 20 хувийг эзэлжээ. 2006-2008 оны нийт эх үүсвэрээс 451 төсөлд 4.6 тэрбум төгрөгийн хөнгөлөлттэй зээл олгожээ.</p> <p>2009 онд 1528 аж ахуйн нэгж, иргэдэд санхүүгийн дэмжлэг үзүүлсний үр дүнд 366 үйлдвэр шинээр байгуулагдаж, 950 гаруй жижиг, дунд үйлдвэр үйл ажиллагаагаа өргөтгөж 5502 ажлын байр шинээр бий болж, 18700 ажлын байр хадгалагджээ.</p>							
8	Хөтөлбөрийн гол үйл ажиллагаа	<p>Жижиг, дунд үйлдвэрийг дэмжих эрх зүйн таатай орчинг бүрдүүлэх зорилтын хүрээнд:</p> <p>- “Жижиг, дунд үйлдвэрийн тухай” хууль, “Санхүүгийн түрээсийн тухай” хууль, “Татварын багц хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” хууль, Нийгмийн даатгалын хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл боловсруулан батлуулсан. “Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай”, “Гаалийн татварын тухай” хуульд нэмэлт, өөрчлөлт оруулан батлуулсан.</p> <p>- Жижиг, дунд үйлдвэрийн асуудал эрхэлсэн Засгийн газрын агентлаг байгуулах шийдвэр гаргуулан, тус газрын төсвийн тооцоо, стратеги, бүтэц зохион байгуулалтын хөтөлбөрийг боловсруулан батлуулан, ЖДҮ-ийн газар</p>								

		<p>байгуулсан.</p> <ul style="list-style-type: none"> <li>- Орон нутагт үйлдвэр хөгжүүлэх чиглэл боловсруулж батлуулав.</li> <li>- Лизингийн тухай” хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төсөлд саналыг холбогдох судалгааны хамт өгсөн. Тоног төхөөрөмжийг жижиг, дунд үйлдвэр эрхлэгчдэд санхүүгийн түрээс лизингээр олгох үйлчилгээ хариуцсан нэгж байгуулах, орон нутгийн ЖДҮ эрхлэгчдэд санхүүгийн түрээс /лизинг/-ээр олгох тоног төхөөрөмжийн судалгааг боловсруулж байна.</li> </ul> <p>Төрийн захиргааны байгууллагаас жижиг, дунд үйлдвэр эрхлэгчдэд үзүүлж байгаа үйлчилгээг шуурхай, чирэгдэлгүй болгох зорилтын хүрээнд:</p> <ul style="list-style-type: none"> <li>- Зөвшөөрөл, лицензийн тоог бууруулах зорилгоор Засгийн газрын 2003 оны 222 дугаар тогтоолд нэмэлт, өөрчлөлт оруулж, Засгийн газрын 2005 оны 127 дугаар тогтоолоор баталгаажуулалтад заавал хамрагдах бүтээгдэхүүний тоог бууруулсан.</li> <li>- Мэргэжлийн Холбоодын нэгдсэн зөвлөлтэй хамтран ажиллан холбогдох хууль тогтоомжид нэмэлт өөрчлөлт оруулах, шинээр боловсруулах үед тус холбоодоор дамжуулан бизнес эрхлэгчдийн саналыг тусгаж байна.</li> <li>- Төрөөс ЖДҮ-ийн талаар баримталж буй бодлого, ЖДҮ төсөл, хөтөлбөр, зээлийн даатгал, тоног төхөөрөмжийн лизинг, хөнгөлөлттэй зээлд хэрхэн хамрагдах, санхүүгийн эрсдэлийг бууруулах арга зам, төсөл хэрхэн бичих зэрэг мэдээллийг олон нийтэд “Нэг цэгийн үйлчилгээ”-гээр дамжуулан хийхээр төлөвлөж байна.</li> </ul> <p>Жижиг, дунд үйлдвэрийг санхүүгийн бодлогоор дэмжих зорилтын хүрээнд</p> <ul style="list-style-type: none"> <li>- Улсын төсвөөс жижиг, дунд үйлдвэрийг дэмжих зорилгоор 2006-2008 онуудад тус бүр 1 тэрбум төгрөг, 2009 онд 30.8 тэрбум төгрөгийн хөнгөлөлттэй зээлийн хөрөнгө баталсан. Төсөл шалгаруулах комисс, хяналтын зөвлөлийн бүрэлдэхүүн, комиссын ажиллах журмыг боловсруулан, арилжааны 3-5 банктай хамтран ажиллах гэрээ байгуулсан. 2006, 2007, 2008 онуудад нийт 4.8 тэрбум төгрөгийн сан бүрдэн, нийслэл, аймгуудад хуваарилан, орон нутгийн ЖДҮ-ийн дэд сангаас дэд комиссын шийдвэрээр арилжааны банкаар дамжуулан 451 төсөлд 4.6 тэрбум төгрөгийн хөнгөлөлттэй зээлийг ЖДҮ эрхлэгч иргэн, аж ахуйн нэгжид 2 жилийн хугацаатайгаар, жилийн 12 хувийн хүүтэйгээр олгожээ. 2006, 2007 оны сангийн зарцуулалт 100 хувь, 2008 оны сангийн зарцуулалт 90 хувь байна.</li> <li>2009 онд улсын төсвөөс 30.8 тэрбум төгрөг, 2006-2008 оны эргэн төлөлтөөс 1 тэрбум, орон нутгаас 0.8 тэрбум, арилжааны банкнаас 9.5 тэрбум, нийт 41.4 тэрбум төгрөгийн эх үүсвэрийг бүрдүүлэн аймаг, нийслэлийн ЖДҮ-ийг дэмжих дэд санд төвлөрүүлэн, хөнгөлөлттэй зээлд хамрагдахаар иргэд, аж ахуйн нэгжүүдээс 89.7 тэрбум төгрөгийн 4595 төсөл ирснээс дэд комисс сонгон шалгаруулж холбогдох банкинд шилжүүлж 1528 аж ахуйн нэгж, иргэдэд санхүүгийн дэмжлэг үзүүлэв.</li> <li>- “Монголд үйлдвэрлэл хөгжүүлэ” төслөөс зээлийн баталгааны сан байгуулан, 516 сая төгрөгийн зээл олгожээ.</li> <li>- Зээлийн баталгааны сангийн эрх зүйн орчинг бүрдүүлэх, зээлийн баталгааны санг тогтвортой үйл ажиллагаа явуулах чадвар бүхий мэргэжлийн санхүүгийн байгууллага болгох санал боловсруулах талаар ажиллаж байна.</li> </ul> <p>Жижиг, дунд үйлдвэрлэлийн хэрэгцээ, шаардлагад нийцсэн сургалт явуулах, мэдээллээр хангах, зөвлөгөө өгөх, дэмжлэг үзүүлэх тогтолцоо бий болго” зорилтын хүрээнд:</p> <ul style="list-style-type: none"> <li>- Бизнес инкубаторын дүрэм боловсруулан батлуулсан.</li> <li>- Технологи дамжуулах төвийг Уланбаатар хотод байгуулж үйл ажиллагааг эхлүүлсэн.</li> <li>- НҮБХХ-тэй хамтран “Монголд үйлдвэрлэл хөгжүүлэ” төслийн туслалцаатайгаар 4-н бүс, Улаанбаатар хотод Бизнесийг дэмжих Зөвлөгөө өгөх төвүүдийг байгуулсан. Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын шугамаар Дархан-Уул, Дорнод, Өвөрхангай, Увс аймаг, Налайх дүүрэгт, Улаанбаатар хотын 4 дүүрэг, Завхан, Орхон, Сэлэнгэ, Хөвсгөл аймгуудад бизнес инкубатор төвүүд байгуулав. Улаанбаатар хот, Архангай, Баян-Өлгий, Баянхонгор,</li> </ul>
--	--	--

		<p>Булган, Дорноговь, Дундговь, Өмнөговь, Сүхбаатар, Төв, Ховд, Хэнтий, Орхон аймгуудад бизнесийн хөгжлийг дэмжих төвүүд байгуулж, жижиг, дунд үйлдэр эрхлэгчдэд зориулж семинар, сургалт зохион явуулж байна.</p> <p>- Олон улсын хөдөлмөрийн байгууллагын “Бизнесээ эхэл, бизнесээ хөгжүүл” хөтөлбөрийг Монгол улсад нэвтрүүлж, сургалтыг Улаанбаатар хот, 21 аймагт 160 удаа зохион байгуулж, 2478 хүнийг сургажээ.</p>
9	<p>Дүгнэлт /хөтөлбөрийн хэрэгжилтийн үр дүн, үр ашиг, үр өгөөж/</p>	<p>Хяналт-шинжилгээ, үнэлгээг Засгийн газрын 2010 оны 11 дүгээр тогтоолоор баталсан ”Яам, аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газрын үйл ажиллагааны үр дүнд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх журам”-ыг удирдлага болгож ХҮБХЗГ-аас гаргасан уг хөтөлбөрийн хэрэгжилтийн тайлан, холбогдох статистик мэдээллүүдийг үндэслэн хийв.</p> <p>Хөтөлбөрийн нэгдүгээр үе шат 2005-2006 оны арга хэмжээнүүд 90, хоёрдугаар үе шат 2007-2008 оны арга хэмжээнүүд 90 хувийн биелэлттэй хэрэгжсэн.</p> <p>Засгийн газрын 2009 оны 280 тогтоолоор батлагдсан “Жижиг, дунд үйлдвэрийг дэмжих хөтөлбөрийг 2009-2010 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө”-ний арга хэмжээ тус бүрийн хэрэгжилтийг үндэслэн хяналт-шинжилгээг хийв. Хөтөлбөрийн гуравдугаар үе шатны арга хэмжээний хэрэгжилтийн явц 2009 оны байдлаар 60 хувьтай дүгнэгдэв.</p> <p>Жижиг, дунд үйлдвэрийг дэмжих эрх зүйн таатай орчин бүрдсэн. “Жижиг, дунд үйлдвэрийн тухай” хууль батлагдсан, тэргүүлэх чиглэлийг баталгаажуулсан. Санхүүгийн түрээсийн хуулийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, ЖДҮ-ийн тухай хуулийн дагуу ЖДҮ-лэл эрхлэгчдийн бүртгэх ажил удааршралтай хэрэгжиж байна.</p> <p>Жижиг, дунд үйлдвэрлэлийг татвар, даатгал, санхүүгийн бодлогоор дэмжих арга хэмжээг сайн хэрэгжүүлсэн. ЖДҮ-ийг дэмжих зээлийн эх үүсвэрийг бүрдүүлэн 2006-2008 онд 451 төсөлд 4.6, 2009 онд 1528 төсөлд 25.8 тэрбум төгрөгийг хөнгөлөлттэй зээлийг ЖДҮ-лэл эрхлэгч иргэн, аж ахуйн нэгжид олгожээ. Цаашид ЖДҮ эрхлэгчдийн зээлийн барьцааны чадавхийг нэмэгдүүлэх, зээлийн баталгааны болон даатгалын системийг бүрдүүлэх, ЖДҮ-т зориулан бага хүүтэй, урт хугацааны арилжааны зээлийн эх үүсвэрийг бий болгох арга хэмжээг үр дүнд хүргэх талаар идэвхтэй ажиллах шаардлагатай байна.</p> <p>ЖДҮ эрхлэгчдийн хэрэгцээ шаардлагад нийцсэн сургалтын тогтолцоо бий болгох талаар тодорхой ажил хийгдэж үр дүнд хүрчээ. Бүс нутгийн төвд байгуулагдсан бизнесийг дэмжих төвүүдээр дамжуулан ЖДҮ эрхлэгчдэд сургалт явуулах, мэдээллээр хангах, зөвлөгөө өгөх дэмжлэг үзүүлж байна. Гэвч байгуулагдсан бөсiаi дэмжих төвүүдийн ʘeē āaeēēāāāā дэмжих, хамтран ажиллах талаар санаачлагагүй ажиллаж байна. Орон нутагт бөсiаi eīēōāāōiō øēiуō āāēābōēāō, бүсийн төвүүдэд Технологи дамжуулах төв байгуулах ажил санхүүжилт шийдвэрлэгдэхгүй улмаас хэрэгжээгүй байна.</p> <p>Жижиг, дунд үйлдвэрийн мэргэжлийн боловсон хүчин бэлтгэх асуудал эхлэл төдий хэрэгжиж байна.</p> <p>Төрийн захиргааны байгууллагаас жижиг, дунд үйлдвэр эрхлэгчдэд үзүүлж байгаа үйлчилгээг шуурхай хүргэхээр нийслэлийн ЗДТГ-тай хамтран дүүргүүдэд “Нэг цэгийн мэдээллийн үйлчилгээ”-г бий болгох бэлтгэл ажил хийгдэж байна. Уг ажил удаашралтай хэрэгжиж байна. Төрийн захиргааны бүх шатны байгууллагаас аливаа бүртгэл, лиценз, зөвшөөрлийг цахим сүлжээгээр олгох тогтолцоог бүрдүүлэх арга хэмжээний биелэлт хангалтгүй байна.</p>
10	<p>Хүлээгдэж буй үр дүндээ хүрээгүй бол шалтгаан, нөлөөлсөн хүчин зүйлс</p>	<p>Хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний хөрөнгийн эх үүсвэр хугацаандаа олгогдохгүй, ЖДҮ-ийг дэмжих урт хугацаатай хөнгөлөлттэй зээлийн асуудлын шийдвэрлэлт удаашралтай, жижиг дунд үйлдвэрлэгчид, үйлдвэрлэлийн технологийн мэргэшлийн ажилчны мэдлэг боловсрол, чадвар дутмаг зэргээс хамаарч хөтөлбөрийн зарим арга хэмжээ хугацаандаа хэрэгжихгүй байна.</p>

11	Эдгээрээс гарах арга зам	<ul style="list-style-type: none"> <li>- Татварын болон бусад хууль тогтоомжид оруулан баталсан нэмэлт, өөрчлөлт, бизнес эрхлэгчдэд учирч буй хүнд суртлыг багасгах, зөвшөөрөл, лицензийн тоог бууруулах, хураамжийн ачааллыг багасгах талаар хийгдсэн ажлуудын үр дүнг тооцох,</li> <li>- ЖДҮ эрхлэгчдийн зээлийн барьцааны чадавхийг нэмэгдүүлэх, зээлийн баталгааны талаар тодорхой үр дүнтэй арга хэмжээ хэрэгжүүлэх,</li> <li>- Аймгуудын ХХААЖДҮГ-тай хамтран ажиллах, удирдамж, зөвлөмжөөр хангах,</li> <li>- Зээл олгогч банкуудын зээл олголт, эргэн төлөлтийн байдалд дүгнэлт өгөн, банкуудтай байгуулсан гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах,</li> <li>- Хот, орон нутагт байгуулсан бизнес дэмжих төвүүдийн үйл ажиллагааг дэмжих, хяналт-шинжилгээ хийж, үнэлгээ өгөх, удирдамж, зөвлөмжөөр хангах,</li> <li>- Технологи дамжуулах дэд бүтцийг бүрдүүлэх талаар санаачлагатай ажиллах,</li> <li>- Жижиг, дунд үйлдвэрийн мэргэжлийн боловсон хүчин бэлтгэх асуудлыг холбогдох яамтай хамтран зохион байгуулах,</li> <li>- Хөтөлбөрийн үндэсний зөвлөлийн үйл ажиллагааг нь тогтмолжуулах, хөтөлбөрийн үе шатны зорилтыг хэрэгжүүлэх төлөвлөгөө болон тухайн оны үйл ажиллагааны төлөвлөгөөнд хүрэх үр дүн, үр дүнгийн шалгуур үзүүлэлт, шаардагдах хөрөнгийн хэмжээг тодорхой тусгах, хэрэгжилтийг хангахад шаардагдах санхүүжилтийн эх үүсвэрийг тухай бүр гаргуулах асуудлыг шийвэрлэх, хөтөлбөрийн хэрэгжилтийн тайлан хэлэлцэх, хэрэгжилтийг ханган ажиллах.</li> </ul>
12	Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд оролцогч талуудын талаархи үнэлгээ	Энэ хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд оролцогч талууд сайн ажилласан. Цаашид яамд, банк санхүү, эрдэм шинжилгээ, төрийн бус байгууллага, хоршоод, их дээд сургуулийн хамтын ажиллагааг улам сайжруулах шаардлагатай.
13	Хөтөлбөрийн талаархи яамны санал	Хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг оны хуваарьтай үр дүнгийн шалгуур үзүүлэлт, хэрэгжилтэд шаардагдах санхүүжилтийг тодорхой тусган боловсруулан батлуулах, уг санхүүжилтийг цаг хугацаанд гаргуулах асуудлыг Сангийн яам, Засгийн газарт оруулан дэмжлэг авах.

ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГА

Т.ГАНТУЛГА